

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

№ 1

Улаанбаатар
хот

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, БЗД, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 23-01 тоотод байрлах “Багануур-Илч” ХХК-ийн 2 давхарт хурлын танхимд хуралдав.

ХУРЛЫН ИРЦ: “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерийн пүүсүүдээр дамжуулан 30,375 ширхэг хувьцааг төлөөлж саналын хуудсаар, 20,147,438 ширхэг хувьцааг төлөөлж 2 хүн итгэмжлэлээр, 591 ширхэг хувьцаа эзэмшигч 2 хүн өөрийн биеэр, нийт 20,178,404 хувьцаа эзэмшигч оролцож хурал 96.21 хувийн ирцтэй хуралдав.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

д/д	Нэр	Албан тушаал
1.	О.Хулан	“Багануур” ХК-ийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Хурал даргалагч
2.	М.Цэнгэл	“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч
3.	Г.Ганзориг	Хурал зохион байгуулах комиссын дарга, “Багануур” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
4.	Б.Наранчимэг	Тооллогын комиссын дарга, “Багануур” ХК-ийн Дотоод хяналт шалгалтын албаны дарга
5.	Д.Даваадаш	Тооллогын комиссын гишүүн, “Багануур” ХК-ийн Санхүү бодлогын хэлтсийн мэргэжилтэн
6.	Б.Наранцэцэг	Тооллогын комиссын гишүүн, “Багануур” ХК-ийн Дотоод хяналт шалгалтын албаны мэргэжилтэн
7.	У.Батсуурь	Хурал зохион байгуулах комиссын гишүүн, “Багануур” ХК-ийн Төлөөлөгчийн газрын менежер

ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

1. О.Хулан - “Багануур” ХК-ийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Хурал даргалагч
2. М.Отгонбаяр – Хувьцаа эзэмшигч /Монголиан нейшнл коул корпорейшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/
3. С.Уранчимэг - Хувьцаа эзэмшигч
4. Д.Алтансүх - Хувьцаа эзэмшигч

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ТАНИЛЦУУЛСАН:

1. М.Цэнгэл - “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч
2. Д.Ганзориг - “Багануур” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ТАНИЛЦУУЛГА ХИЙСЭН:

1. М.Цэнгэл – “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч
2. Д.Ганзориг – “Багануур” ХК-ийн Санхүү хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай.
2. “Багануур” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Наранчимэг /Тооллогын комиссын дарга/: “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулав. Ирц бүрдсэн тул хурлыг хуралдуулахыг зөвшөөрч байна.

О.Хулан: Хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлыг дэгийг танилцуулав. Нэгдүгээр асуудал болох “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг танилцуулна уу.

М.Цэнгэл “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч: “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг танилцуулав.

Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлт.

- Нүүрс борлуулалтын гүйцэтгэл 108.7%
- Нийт уулын ажлын гүйцэтгэл 118.7%
- Техник ашиглалт ТББК-72.0% ТАК-68.0%
- Уурхайн хүчин чадал ашиглалт 108.5%
- ХАБЭА-ны зөрчилгүй 100%
- Ашигт ажиллагаа 1,510.1 сая төгрөг

Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын чиглэлээр.

- Тоног төхөөрөмжийн шинэчлэл. Толгой компаний тус зээлд батлан даалт гаргасан тул ЯОУХАБ-ийн хөнгөлөлттэй зээл авсан тоног төхөөрөмжүүд 2021 оны 1-3 сард уурхай дээр ирж ашиглалтад хүлээн авсан.
- 110/6 кв-ын уулын станцыг шинээр барих төсөл. Гүйцэтгэл 80% 2022 онд ашиглалтанд хүлээн авна.
- Төмөр замын трасс өөрчлөх төсөл. Гүйцэтгэл 100% 2021 онд ашиглалтанд хүлээж авсан.
- Ус шүүрүүлэх цооног. 2021 онд өөрийн хөрөнгөөр 10 ш ус шүүрүүлэх гүний цооногийг ашиглалт хүлээн авсан.

Компанийн өртөг зардал бууруулах чиглэлээр.

- Эрчим хүчний нүүрсний үнэ. 2017 оноос хойш Багануур ДС-ийн 1 тн нүүрсийг 11,000 төгрөгөөр олгож байсныг ЭХЗХ-нд удаа дараа хүсэлт явуулсны дүнд 2021 оны 2 дугаар сараас 33,500 төгрөгөөр борлуулах болсон.
- Хэмнэлтийн төлөвлөгөө. 2021 онд 1.4 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргах төлөвлөгөө боловсруулан ажилласнаас гүйцэтгэлээр 2.1 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж 151.4%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.
- Хөрөнгө актлах. ТУЗ-ийн шийдвэрээр: Нийт 2,386.3 сая төгрөгийн хөрөнгийг ТУЗ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №13 тоот тогтоолоор актлаж данснаас хассан.
- Компанийн сайн засаглал, ил тод байдал. Компанийн 2018 оноос жилийн тайланг олон улсын жишиг загварын дагуу нэгтгэн тайлагнасан. Шилэн дансны тухай хуультай уялдуулан компанийн хэмжээнд мөрдөн ажиллах журмыг боловсруулан тайлан мэдээллүүдийг бүрэн тайлагнан ажилласан.

Хүний нөөцийн мэдээлэл.

- Нийт 1139 ажилтан ажиллаж байна. Үүнээс Удирдлага 25, Мэргэжилтэн 29, ИТА 75, Ажилтан 48, Мэргэжлийн ажилтан 816, Туслах ажилтан 146.

Хуралд танилцуулсан материалыг хавсаргаав.

О.Хулан: Хоёрдугаар асуудал болох “Багануур” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг танилцуулна уу.

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Д.Ганзориг: “Багануур” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд өгсөн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг танилцуулав.

Аудитын тайлан. “Багануур” ХК-ийн 2021 оны 1 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүү, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт авсан.

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж.

- НДШ-ийн суутгал. Ажиллагсдын төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 1 хувийг компаниас төлж байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-дэх “Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь 2 байна” заалтыг зөрчиж байна. Зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ажилтнаас 2 хувиар суутгаж нийгмийн даатгалын санд төвлөрүүлж байх.
- Санхүүгийн дансны төлөвлөгөө. Багануур ХК нь сангийн сайдын 2000 оны 116 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, Сангийн сайдын 2017 оны 248 дугаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн маягыг ашиглаж байна. Зөвлөмж: Компанийн санхүүгийн программ дахь дансны төлөвлөгөө, нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй болон хураангуй журналын маягыг Сангийн сайдын 249, 100 дугаар тушаалд нийцүүлэх.
- НБББББ-ийн талаар. Багануур ХК нь санхүүгийн үйл ажиллагаандаа ЭМГЛ ХХК-ийн группийн хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн бүртгэлээ хөтлөж байгаа нь зарим талаараа байгууллагын үйл ажиллагаа болон бүртгэлийн нийтлэг зарчимд нийцэхгүй байна. Зөвлөмж: Компанийн бизнесийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн НБББББ-ийг шинэчлэн боловсруулах.
- Худалдан авалт. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1-ийг зөрчсөн 21,083.0 сая төгрөгийн 427 бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан шууд гэрээ байна. Шаардах нь: Бараа, ажил гүйлгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үндэсний аудит”-ын газарт ирүүлэх.
- И-баримтгүй худалдан авалт. ААНОАТ-ын тухай хуулийн 13.1.4 аж ахуйн нэгжийн бараа, ажил, үйлчилгээний зардал дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх гэсэн заалтыг зөрчсөн 5,481.2 сая төгрөгийн зөрчил гарсан. Шаардах нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу И баримтгүй худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үндэсний аудит”-ын газарт танилцуулах.

Зөвлөмжийн дагуу хийх ажлууд.

- Ажилчдын эрүүл мэндийн даатгалын 1%-ийн шимтгэл. Тус асуудал нь ямар нэгэн хууль зөрчөөгүй бөгөөд бид тайлбарыг үндэсний аудитын газарт хүргүүлэн ажиллана.

- Сангийн сайдын 2017 оны 348 дугаар тушаалын дагуу маягтыг солих. Толгой компани дээр нэгдсэн ERP систем хийгдэж байгаа тул түүнтэй уялдуулах эсвэл бизнес төлөвлөгөөнд тодотгол хийж шинээр ERP систем нэвтрүүлэх.
- НББББББ-ийг өөрийн үйл ажиллагаанд тохируулан шинэчлэх. Толгой компани дээр нэгдсэн бодлогын бичиг баримт хийгдэж байгаа тул түүнтэй уялдуулах эсвэл бизнес төлөвлөгөөнд тодотгол хийж бодлогын баримтыг хийлгэх.
- Харилцагч компанитай тооцоо нийлж баталгаажуулах. 1 компанийн 550 сая төгрөгийн авлагыг шүүхэд өгч шийдвэрлүүлэх. 8 компанийн 99.7 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлэх. 2 компанийн 11.1 сая төгрөгийн авлагын бичиг баримтыг эцэслэн дуусгах. 4 компанийн 19.8 сая төгрөгийн үлдэгдэл зөрүүтэй байгааг эцэслэх. 24 ажилчны 3.2 сая төгрөгийн цалингийн авлагыг суутгаж дуусгах.
- Бараа ажил үйлчилгээ худалдан авах хууль тогтоомж хэрэгжүүлээгүй. Хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авалтыг зохион байгуулна.
- Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож бүртгэсэн. Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь ажиллана /шилэн дансны тухай журмыг шинэчлэсэн/
- И-баримтгүй 5,481.2 сая төгрөгийн худалдан авалт. 2021 оны 11 сарын 1-ны өдрөөс эхлэн И-баримтгүй худалдан авалт хийгээгүй.

Хуралд танилцуулсан материалыг хавсаргав.

О.Хулан: Гуравдугаар асуудал болох Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг танилцуулна уу.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч М.Цэнгэл: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлыг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудлын хүрээнд хувьцаа эзэмшигч, толгой компани “Эрдэнэс Монгол” ХХК-аас Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт, жишигт нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож байх эрхийг “Багануур” ХК-ийн толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-д олгох санал өгөх удирдамж өгсөн. Үүнтэй уялдуулаад Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсийг нэгдсэн нэгж жишигт оруулаад, нэг дүнтэй болгох асуудлаар ажиллаж байна. Үүнтэй холбоотой тогтоолын төслийг та бүхэнд танилцуулья.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, ““Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөллийг охин болон хараат компанид хэрэгжүүлэх тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.3 дахь заалтууд, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар баталсан удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт, жишигт нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож байх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, холбогдох шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

О.Хулан: Дөрөвдүгээр асуудал болох Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг хэлэлцье.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч М.Цэнгэл: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг танилцуулав.

Дөрөвдүгээр асуудлын хүрээнд 21 хувийн хувьцаа эзэмшигч Монголиан көүл корпорейшн компанийн зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлд сонгох гишүүдийн нэрийг

М.Отгонбаяр, Д.Чинбат гэж ирүүлсэн байгаа. Өнөөдрийн хувьд төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүд болон хараат бус гишүүдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн дагуу Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байгаа. Холбогдох газраас хариу ирэхээр ээлжит бус хурлаа зарлаад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгоод явна.

О.Хулан: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлынхаа танилцуулгыг сонсож дууслаа. Одоо Хувьцаа эзэмшигчид асуулт асууж холбогдох албан тушаалтнууд хариулна.

Толгой компаниас хоёрдугаар асуудалтай холбоотой асуух асуулт байна. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолоор өгсөн чиглэлийг яаж хангаж ажиллах вэ?

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Д.Ганзориг: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын ногдол ашиг хуваарилах талаарх хэсгийг асууж байх шиг байна. Ногдол ашгийн тухайд өнгөрсөн долоо хоногт Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулсан байгаа. Компани 2021 оны жилийн эцсийн тайлангаар 1 тэрбум 500 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Ашигтай ажиллахад нөлөөлсөн гол хүчин зүйл бол Эрдэнэс Монгол компанитай хамтран хэрэгжүүлсэн техникийн шинэчлэлийн хүрээнд Японы олон улсын хамтын ажиллагааны банкнаас тоног төхөөрөмжийн зээл авсан. Энэ зээлийн ханшийн тэгшитгэлийн олзыг зохих зөвлөмжийн дагуу бүртгэсэн. Энэ нь бол компанийн мөнгөн урсгалаараа орж ирж байгаа нэмэлт орлого биш гэж үзсэн. Хоёрдугаарт Команийн тухай хуулийн 47.1.1-д заасны дагуу ногдол ашиг хуваарилсны дараа төлбөрийн чадвартай байх гэдэг заалт байгаа. Энэ заалтыг хангах хүрээнд ногдол ашиг хуваарилахгүй байхаар Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлэсэн байгаа.

О.Хулан: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байна уу?

Д.Алтансүх: Төрийн уул уурхайн компаниудын баланс тайланг ерөнхийдөө үзлээ. Өнөөдрийн хувьд хурлыг харахад бол Багануур компанийн тайланг харахад анх удаагаа ашигтай тайлан харж байна. Багануур компанийн хамт олонд баярлалаа. 1.5 тэрбум төгрөгийн ашигтай гарах нь бас том үзүүлэлт юм. Та нарт баяр хүргэе.

М.Отгонбаяр: Компанийн дотоод хяналтынхан хэр ажиллаж байгаа вэ? Дотоод хяналтын тайлан гэж байна уу?

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Д.Ганзориг: Компанийн бүтцээр Гүйцэтгэх захирлын харьяалалд дотоод хяналтын нэгж ажилладаг. Нэг дарга, 5 мэргэжилтэн ажиллаж байна. Мэргэжилтэн тус бүр чиглэл чиглэлээрээ ажилладаг. Үйлдвэрлэл үйл ажиллагаа, хөдөлмөрийн авулгүй байдал, эрүүл ахуй, санхүү, худалдан авах ажиллагаа гээд. Өөрсдийнх нь хяналт шалгалтын дотоод журамтай. Энэ журмынхаа дагуу ээлжит болон ээлжит бус шалгалтуудаа хийгээд явдаг. 2021 оны санхүүгийн тайланд бүх хяналт шалгалтуудаа хийсэн гэж би ойлгож байгаа. Бүтцээрээ шууд Гүйцэтгэх захиралд харьяалагддаг. Компанийн шилэн дансны хөтлөлттэй холбоотой асуудлаар дотоод хяналтын албаны зүгээс сайн ажилласан. Энэ дагуу шилэн дансны хөтлөлттэй холбоотойгоор холбогдох журамд өөрчлөлтүүд ороод хэрэгжүүлээд явж байгаа.

М.Отгонбаяр: Энийг яагаад асууж байна гэхээр. Бид нар компани ашигтай байлгахын төлөө нэг зүгт явж байгаа. Компани дээр санхүүгийн аудитын шалгалтууд хийгддэг. Үйл ажиллагаа хаанаа болохгүй байна гээд олон асуудлууд байгаа. Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагаагаар илэрэхгүйдээ. Энэ дээр анхаарч ажилламаар юм болов уу. Бид нар захирлаас хэрэгжүүлж байгаа компанийн ажлыг дэмжиж ажиллах үүрэгтэй. Ингэж ажиллахад дотоод хяналтын ажлаар гарч ирсэн зөрчлийг Төлөөлөн удирдах зөвлөлдөө нуулгүйгээр танилцуулж, яаж арилгах вэ, яаж хамтарч ажиллах вэ гэж ажиллах хэрэгтэй. Мөн аудитын зөвлөмжүүд дээрээ сайн анхаарч ажиллаарай.

Нийгмийн даатгалын шитгэл дээр түрүүн юу ярьсан бэ? Тодруулж өгөөч?

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Д.Ганзориг: Нийгмийн даатгалын шимтгэл 3 хувь төлж байгаа. 2 хувийг ажил олгогчийн зүгээс 1 хувийг ажилтан төлж байгаа. Хууль тогтоомжид зааснаар ажилтан 2 хувь төлөх зохицуулалттай. Манайх Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын гэрээгээр 1 хувийг ажилтнаас авч байгаа. Хөдөлмөрийн тухай

хууль тогтоомжийн дагуу байгуулсан хамтын гэрээний хүрээнд энэ асуудлыг зохицуулж байгаа.

О.Хулан: Асуулт хариулт дууссан бол “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2022 оны 10 дугаар тогтоолоор баталсан удирдамжийг уншиж танилцуулья.

“Багануур” ХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг дараах удирдамжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Хэлэлцэх асуудал. “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай.
Удирдамж. “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх.
2. Хэлэлцэх асуудал. “Багануур” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай.
Удирдамж. “Багануур” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж санал, дүгнэлт өгөх. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 88 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авах.
3. Хэлэлцэх асуудал. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.
Удирдамж. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт, жишигт нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож байх эрхийг “Багануур” ХК-ийн толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-д олгох санал өгөх.
4. Хэлэлцэх асуудал. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.
Удирдамж. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу томилох.

О.Хулан: Хурлын дэгийн дагуу хурлын үйл ажиллагаа 20 минут завсарлав. Энэ хугацаанд хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа гарган Тооллогын комисст өгөв.

О.Хулан: Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Б.Наранчимэг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Наранчимэг:

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, дугаар 02.

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,178,404 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 5 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй. Санал өгсөн байдлыг үзвэл:

1.Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Зөвшөөрсөн 4,417,259.00 санал, 22%

Татгалзсан 15,761,145.00 санал, 78%

Түдгэлзсэн санал байхгүй.

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, дугаар 03.

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,178,404 ширхэг саналын эрх бүхий хувь

нийлүүлэгчид оролцож 5 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй. Санал өгсөн байдлыг үзвэл:

1.“Багануур” ХК-ийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай.

Зөвшөөрсөн 4,417,259.00 санал, 22%

Татгалзсан 15,761,145.00 санал, 78%

Түдгэлзсэн санал байхгүй.

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, дугаар 04.

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчдээс 20,178,404 ширхэг саналын эрх бүхий хувь нийлүүлэгчид оролцож 5 ширхэг саналын хуудсаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас байхгүй. Санал өгсөн байдлыг үзвэл:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.

Зөвшөөрсөн 20,148,029.00 санал, 100%

Татгалзсан 30,375.00 санал, 0%

Түдгэлзсэн санал байхгүй.

О.Хулан: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг танилцуулав.

Нэгдүгээр асуудлын хүрээнд: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар тогтоолоор баталсан удирдамжийн дагуу “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд өгсөн “Хангалттай” гэсэн дүгнэлтийг батлахгүй байхаар шийдвэрлэж, тогтоолын төслийг танилцуулья.

Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2.2022 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Хоёрдугаар асуудлын хүрээнд: Компанийн санхүүгийн тайлан, түүнд өгсөн хөндлөнгийн аудитын дүгнэлт, танилцуулга болон хувьцаа эзэмшигчээс өгсөн удирдамжийн дагуу “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Багануур” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд өгсөн “Хангалттай” гэсэн дүгнэлтийг батлахгүй байхаар шийдвэрлэж, тогтоолын төслийг танилцуулья.

Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2.2022 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангах, 2021 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилах чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулан толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Гуравдугаар асуудлын хүрээнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, ““Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөллийг охин болон хараат компанид хэрэгжүүлэх тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.3 дахь заалтууд, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар баталсан удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт, жишигт нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн тогтоож байх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д олгосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, холбогдох шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дөрөвдүгээр асуудлын хүрээнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр шийдвэрлэв.

О.Хулан: Энэ гаргасан шийдвэрийг та бүгд ойлгож байгаа байх. Аудитын дүгнэлтүүд байна. Материаллаг буруу илэрхийлсэн эрсдэл ихтэй гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0,5 хувиар тогтоосон байгаа. Шалгалтын явцад төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 145 тэрбум төгрөгөөс 0,5 хувь буюу 725 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг суурь үзүүлэлт, түүнээс тооцох хувийг өөрчлөөгүй буюу 2021 оны нийт зардлын 150 тэрбум төгрөгнөөс 0,5 хувиар буюу 724,6 сая төгрөгөөр тогтоосон гэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтүүд гарсан. Материаллаг байдлыг мнгэж тогтоосон байхад нийт 61,9 төгрөгийн ноцтой алдаа зөрчлүүд илэрсэн. Мөн хууль зөрчин 21,1 тэрбум төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. Хэдийгээр ковидын хууль байлаа ч гэсэн шууд худалдан авалт дураараа хий гэсэн үг биш. Өнгөрсөн жил мөн Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр энэ асуудал яригдаж байсан байна лээ. Дахин давтан энэ асуудал яригдаж байна. Тийм учир энэхүү ээлжит хурлын тогтоолуудыг баталж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай хуралдаж дууслаа. Идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч нартаа байрлалаа. Хурал хаасныг мэдэгдье.

Хурал 12:25 цагт дуусав.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



О.ХУЛАН

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
Хурал зохион байгуулах комиссын дарга



Г.Ганзориг